



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/195

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтанд аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 1.4 дэх заалт, Жаргалант суманд хийгдэх “Хогийн менежмент, хур хог цэвэрлэх” / ажлын 30.000.000 төгрөг /гучин сая/-ийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Жаргалант сумын Засаг дарга /Ц.Ганданповрон/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хүлээлгэн өгөх, хэрэгжилтийг хангах, арга хэмжээг тайлагнахыг Жаргалант сумын Засаг дарга /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

ZAX A/195 Ch
02 00924

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

